



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 02

Номгон

Г Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, Г тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, төрийн алба хаагчдын үүрэг хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх тухай

Аймгийн Засаг даргын эрхэлх асуудлын хүрээний агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр сумдын Засаг даргын Тамгын газрын 95 хувь, агентлагийн 82.6 хувь, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын 40 хувь, нийт 53 байгууллагын 77.3 хувь нь “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн байна.

Нийт 18 сумын Засаг даргын Тамгын газар, 16 агентлаг, 3 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, нийт 37 байгууллага үйл ажиллагааны үр дүнгээ 2022 оны мөн үеэс 0.5-46.74 хувиар нэмэгдүүлсэн дүнтэй байна.

Байгууллагуудын 2023 оны жилийн эцсээр хийсэн хяналт-шинжилгээний дүнгээр Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Автотээврийн төв, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ОНӨГ, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах үйлчилгээний төв зэрэг байгууллагууд үр дүнгүй, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 4 агентлаг, Төрийн болон орон нутгийн өмчийн 4 байгууллага, 2 сумын Засаг даргын Тамгын газрын үнэлгээ өмнөх үеэс буурсан үзүүлэлттэй үнэлэгдсэн нь байгууллагуудын үйл ажиллагаа тогтворжоогүй, удирдлагын зүгээс тавих дотоодын хяналт, алба хаагчдын үүрэг, хариуцлага сул байгаатай холбон үзэж байна.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

642402001

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, холбогдох хэлтсийн дарга нарт

1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулах тогтолцоог бүрдүүлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэх;

1.2. Хүүхдэд ээлтэй засаглалыг бэхжүүлж, хүүхдийн эрх, оролцоог хангаж ажиллах, Нялхасын эндэгдэлгүй аймаг болох, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлэлтийг бууруулах арга хэмжээ авч, ажиллах;

1.3. Нийгмийн салбарын хороо, зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг нийгмийн бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагыг дэмжиж бодит оролцоог ханган, санхүүжилтийг нэмэгдүүлж салбар дундын уялдаа холбоог сайжруулах;

1.4. Гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;

1.5. Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх;

1.6. Агаар, орчны бохирдлын хэмжээг бууруулах талаар дорвитой арга хэмжээг авч, хэрэгжүүлэх;

1.7. Ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх талаар нэгдсэн бодлого гаргаж, иргэд аж ахуйн нэгжид нийлүүлсэн тарьц, суулгацын хэмжээг нэмэгдүүлэх, үр дүнг тооцох;

1.8. Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах ажлыг зохион байгуулах;

1.9. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хийх сургалт, сурталчилгааны тоог нэмэгдүүлэн, үр дүнд хүргэх;

1.10. Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн талаарх тайланг оновчтой, хугацаанд нь тайлагнах чиглэлээр сургалт, нөлөөллийн болон зөвлөн туслах ажлыг үр дүнтэй зохион байгуулах;

1.11. Нутгийн захиргаа, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхад чиглэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

1.12. Хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр гарсан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын албан даалгаврыг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж, үр дүнд 9-р сард танилцуулах;

1.13. Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд, сум, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөн туслах ажлын үр нөлөө, үр дүнг дээшлүүлэх;

Хоёр. Сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын дарга нарт:

2.1. Удирдах албан тушаалтан бүр удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн, хариуцан ажиллаж байгаа байгууллагын үйл ажиллагааны түвшинг тогтворжуулж, үр дүнг нэмэгдүүлэх талаар бодитой ажил зохион байгуулах;

2.2. Өөрчлөлт, шинэчлэлтийг соргоогоор мэдэрч хүлээн авах, шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, Төрийн албаны шинэчлэл, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Монгол хэлний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;

2.3. Бүсчилсэн хөгжилд тулгуурласан орон нутгийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулахад төрийн бүх байгууллагын удирдлага, албан хаагчид манлайлан ажиллах;

2.4. Бүх шатны байгууллагын төлөвлөлтийн баримт бичгийг сайжруулах, зорилт арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшинг тодорхойлохдоо нөхцөл байдлын дүн шинжилгээ хийсний үндсэн дээр боловсруулж, хэвших;

2.5. Сум бүр эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлттэй болж, мэдээлэл, судалгааны баримт бичигтэй болох;

2.6. Аливаа үйл ажиллагааг зохион байгуулах, төрийн байгууллага, албан тушаалтнаас гарсан шийдвэр, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа холбогдох албан тушаалтны шийдвэр, төлөвлөгөө, удирдамж батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан гүйцэтгэлийн тайланг тухай бүр нь гаргаж хэвших;

2.7. Аливаа гэмт хэрэг, зөрчлөөс ангид байж авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдлагын манлайллыг бий болгон байгууллагынхаа үйл ажиллагааны ил тод байдлыг ханган аймгийн шударга

байдлын түвшинг нэмэгдүүлэх, бүх төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах;

2.8.Аймгаас 2024 оныг “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”болгон зарласан зорилтын хүрээнд байгууллага бүр үр дүнтэй ажил зохион байгуулж,тайланг тухай бүр өгч хэвших;

2.9.Төрийн байгууллага, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд стандарт нэвтрүүлэх;

2.10.Аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сангийн ашиглалтыг сайжруулан, тайлан, мэдээллийн хугацааг чанд баримтлан үр дүнгээр тайлагнаж хэвших, хийгдээгүй орхигдсон болон гүйцэтгэл, үр дүн дутуу гарсан ажлуудыг 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусган хэрэгжүүлэх;

2.11.Төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг үнэлэхдээ Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй уялдуулан дүгнэж хэвших;

2.12. Иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг ханган төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлэх үйлчилгээ болон хуулиар нээлттэй байхаар заасан бусад мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан тогтмол нээлттэй ил тод мэдээлж, байгууллагын ил тод байдлын үнэлгээг өсгөх, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох;

2.13. Мэргэжлийн боловсролын сургууль төгсөгчдийг ажлын байраар хангах зохистой арга хэмжээ авч ажиллах;

2.14.Төрийн албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хослон турших ажлыг төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж, төрийн албан хаагчид хэвшил болгох;

2.15.Инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг үйл ажиллагаанд нэвтрүүлж, зохих заавар журмын дагуу оюуны өмчийн газар бүртгүүлж, патент авч баталгаажуулах;

2.16.Сумдын соёлын төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилтийг хангахаар төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавих, сумын соёлын төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд анхаарч ажиллах;

2.17.Соёл, урлагийн чиглэлээр мэргэжлийн хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.18.Соёл, урлаг, өв соёл, соён гэгээрлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага, иргэн, аж ахуй нэгжийг дэмжиж хамтран ажиллах;

2.19.Сумдын биеийн тамирын арга зүйчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигт Нийтийн биеийн тамир, спортын салбарт хэрэгжүүлэхээр заасан зорилтуудын хэрэгжилтийг хангуулахаар боловсруулж батлах, хэрэгжилтэд хяналт тавьж, хагас бүтэн жилээр ажлыг нь дүгнэх;

2.20.Нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөнөөр хичээллэхийн ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлэх, мэдлэгийг дадал болгоход онцгой анхаарч, салбар дундын оролцоог хангаж ажиллах;

2.21.Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, Багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний хүрсэн түшингээ бататгаж, 2-5 хувиар нэмэгдүүлж ажиллах;

2.22. Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуйн тухай хууль,журам, стандартыг хэрэгжүүлж ажиллах;

2.23.Архив,албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, баримтыг стандарт шаардлагын түвшинд хөтлөх, баримтжуулах,арга зүйгээр хангах, нийт ажилтнуудын хагас бүтэн жилийн ажлын гүйцэтгэл, үнэлгээнд баримтжуулалт, архивлах ажлыг оруулан тооцох, урьд онуудын баримтыг архивт бүрэн хүлээн авах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах зэрэг архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах;

2.24.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар дорвитой арга хэмжээ зохион байгуулж, төрийн үйлчилгээний талаар иргэдийн саналыг цахимаар авч, хэрэгжүүлэх ажлыг улирал зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах;

2.25.Сум,байгууллагын удирдлагууд байгууллагын дотоодын хяналтыг өндөржүүлж ажиллах;

2.26.Бүх төрийн албан хаагчдыг албаны цахим шуудан ашиглаж хэвшүүлэх;

2.27.Өөрийн байгууллагын албан ёсны цахим хуудсанд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж 98 төрлийн заалт бүхий мэдээллийг Нээлттэй байршуулж Shilen.gov.mn тайлагнах;

2.28.Байгууллагын дотоод групп чат буюу зөвхөн И Ар Пи системийн чат группээр албаны мэдээлэл солилцож байх, Facebook, Viber, Telegram зэрэг гадаадад сервертэй системүүд албан хэрэгцээнд ашиглахыг хориглох;

2.29.Цахим аймаг бодлогын хөтөлбөрт өөрийн сум, байгууллага, аймгийн цахимжилтын талаар санал ирүүлэх;

2.30. Өөрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг болон иргэн ААН-дэд үзүүлж байгаа үйлчилгээг хуульд нийцүүлэн цахим хэлбэрт шилжүүлж цаг хугацаа зардлыг хэмнэх;

Гурав. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр үр дүнгүй гэж үнэлэгдсэн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Автотээврийн төв, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ОНӨГ, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах үйлчилгээний төв, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн Жинст сумын Засаг даргын Тамгын газар, Шүүх шинжилгээний хэлтэс, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Сум дундын ой анги ОНӨҮГ, Цэвэр хот ОНӨААТҮГ, Их Богдын байгалийн цогцолборт хамгаалалтын захиргаа зэрэг байгууллагын удирдлагууд дүгнэлт хийж, байгууллагынхаа үйл ажиллагаа, төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлага, ажлын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр гарсан алдаа, дутагдлыг засах, дахин давтахгүй байхад чиглэгдсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй.

Дөрөв. Албан даалгаврын хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж байхыг сумдын Засаг дарга, төрийн бүх шатны байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

Тав. Сум, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаа, ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан ахиц өөрчлөлтийн талаар Засаг даргын удирдлагын багт танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга (Л.Мандал)-д үүрэг болгосугай.

Зургаа. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН